



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 - 6

- 
- 1. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”  
Улсын Их Хурлын тогтоол* 4 - 5
  - 2. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын  
тогтоолын төсөл* 5 - 6

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 27-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 38 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Н.Учрал, Б.Энхбаяр;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, Ш.Раднаасэд, Ц.Сэргэлэн;*

*Тасалсан: Ц.Мөнх-Оргил.*

**Нэг. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дэд дарга бөгөөд Захиргаа, удирдлагын газрын дарга Г.Даваадалай, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал Б.Бат-Орших, Шүүхийн сахилгын хорооны Захиргаа удирдлагын хэлтсийн дарга М.Мөнх-Алдар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал Б.Бат-Орших нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 11 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 49 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр,

Лхагва гараг

Төрийн ордны “Жанжисин Д.Сүхбаатар”

танхим

12 цаг 38 минут

## БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдаанд Дамдины Цогтбаатар ирсэн байна, Ширнэнбаньдийн Адьшаа ирсэн, Норовын Алтанхуяг ирсэн, Сандагийн Бямбацогт ирсэн, Дашдондогийн Ганбат ирсэн, Борхүүгийн Дэлгэрсайхан ирсэн, Лхагвын

Мөнхбаатар ирсэн, Цэрэнжамцын Мөнхцэцэг ирсэн, Жамьянхорлоогийн Сүхбаатар ирсэн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн байна.

Ингээд ирэх ёстой гишүүдийн 10 гишүүн ирснээр 52.6 хувьтайгаар ирц бүрдээд байна.

Байнгын хорооны хуралдаантай холбогдуулж ирцийг танилцууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хоёр асуудал байгаа.

**Нэг.** “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

**Хоёр.** “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн ийм хоёр асуудал байгаа.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналаа өгье. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байхгүй байна.

Тэгэхээр хэлэлцэх асуудлыг баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа орёе.

## Нэг. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэх асуудалтай холбогдсон ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын

Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхэд оролцох ажлын хэсгийн гишүүд.

Л.Энхбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Ц.Давхарбаяр Шүүхийн сахилгын хорооны дарга, М.Чинбат

Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх, Д.Баянбилэг Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Р.Батрагчаа Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Г.Даваадалай Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дэд дарга бөгөөд Захиргаа удирдлагын газрын дарга, С.Гансэлэм Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга, Б.Бат-Орших Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал, М.Мөнх-Алдар Шүүхийн сахилгын хорооны Захиргаа удирдлагын хэлтсийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ингээд “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Үг хэлэх гишүүн алга байна.

Ингээд “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.

Одоо гишүүд танхимдаа орж ирнэ үү. Тогтоолыг нь би түрүүн уншаад танилцуулчихсан. Тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Б.Энх-Амгалан гишүүн танилцуулна.

Дараагийн асуудалдаа орёе.

---

### Хоёр. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

---

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг Та бүхэнд бас тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Алга байна.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их

Хурлын гишүүн Ш.Адьяа гишүүн  
танилцуулна.

70.0 хувиар түрүүн санал  
хураагаад гишүүд дэмжлээ. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар  
хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан  
хаасныг мэдэгдье. Гишүүд ирж  
оролцсонд баярлалаа. /алх цохив/

*Хуралдаан 11 минут үргэлжилж, 12 цаг 49 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**